



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 08 дугаар сарын 12
№ 30 (1228)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

570. Конвенцод оруулсан нэмэлт,
өөрчлөлтийг соёрхон батлах тухай 2327

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

571. Засгийн газарт чиглэл өгөх тухай Дугаар 43 2328

572. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 44 2330

573. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 45 2330

574. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 46 2331

575. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 47 2331

576. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 48 2332

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

577. Кино урлагийн зөвлөлийн талаар авах
зарим арга хэмжээний тухай Дугаар 90 2332

578. Журам батлах тухай Дугаар 92 2346

579. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 97 2349

580. Мэргэжлийн боловсрол, сургалтын
талаар авах арга хэмжээний тухай Дугаар 122 2354

581. Журам батлах тухай Дугаар 132 2358

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 05-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нэг.Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд “Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай:

1.1.Архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд бодлогын болон эрх зүйн өөрчлөлт хийх;

1.2.Онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр 2 хувиар бууруулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

1.3.Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи, согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;

1.4.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;

1.5.“Халамжаас хөдөлмөрт” шилжих суурь шинэтгэлийн хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;



1.6.Архи, согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэл, борлуулалттай тэмцэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох, цахим техник, технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүнд оногдуулах эрүүгийн болон зөрчлийн ял, шийтгэлийн бодлогод өөрчлөлт оруулах;

1.7.Хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах агуулгыг тусгах;

1.8.Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;

1.9.Согтууруулах ундааны шошгон дээр согтууруулах ундааны хор уршиг, сөрөг нөлөөний талаарх анхааруулга, санамж байршуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хоёр.Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.

Гурав.Энэхүү зарлигийн хэрэгжилтийн явцыг олон нийтэд цаг тухай бүр мэдээлж, тайлан мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчид жил бүр ирүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

**ЛУВСАННАМСРАЙН
ОЮУН-ЭРДЭНЭ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лүндэгийн Пүрэвсүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваасүрэнгийн Гэрэлмааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батлайн Чулуунхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдинсүрэнгийн Даваасүрэнг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Ирланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нархүүгийн Тулгыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Ирланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Баттөмөрийн Энхсүхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Исланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нархүүгийн Тулгыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Исланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Түвдэндоржийн Жанабазарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Мальдив Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гончигийн Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Мальдив Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбажавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Кино урлагийг дэмжих тухай хуулийн 6.1.4, 6.1.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Кино урлагийн зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Кино урлагийн зөвлөлийн ажиллах журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. “Кино урлагийн зөвлөл”-ийн ажлын албыг байгуулан дүрмийг 3 дугаар хавсралтаар баталж, орон тооны хязгаарыг 18 байхаар тогтоосугай.

3. Кино урлагийн зөвлөл болон Ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Соёлын сайдын батлагдсан төсвийн багцад багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.



4. Кино урлагийн зөвлөлийн дарга, гишүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 90 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Кино урлагийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн дарга, гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.2. Зөвлөлийн дарга, гишүүнийг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, ашиг сонирхлоос ангид байх, шударга, ил тод, хараат бус байх, эрх тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалт зарлах, нэр дэвшүүлэх

2.1. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах талаар болон холбогдох материал хүлээн авах, бүртгэх хугацааг товлож олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

2.2. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.3-д заасны дагуу төсөв, санхүү, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж буй холбогдох нэгжийн даргын нэрийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр ирүүлнэ.

2.3. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.4, 9.5-д заасан Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь энэ журмын 2.5 дахь заалтын хүрээнд зөвхөн нэг чиглэлийг сонгон мэргэжлийн төрийн бус байгууллагаас, эсхүл бие даан нэр дэвшиж болно.

2.4.Энэ журмын 2.3-т заасан нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.4, 9.5-д заасан шаардлагыг хангасан байх;

2.4.2.ял шийтгэлгүй байх;

2.4.3.төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан биш байх;

2.4.4.урлаг, уран сайхны болон кино урлагийн бизнесийн чиглэлээр тодорхой амжилт гаргасан, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байх.

2.5.Энэ журмын 2.3-т заасан нэр дэвшигч нь дараах чиглэлүүдээс сонгоно:

2.5.1.продюсерын;

2.5.2.найруулагчийн;

2.5.3.зураглаачийн;

2.5.4.зохиолчийн (утга зохиол, кино зохиол);

2.5.5.кино түгээлт, кино наадмын;

2.5.6.нийгэм, соёлын антропологи, урлаг судлал, кино судлал, кино урлагийн боловсрол олгох;

2.5.7.кино урлагтай холбоотой сургалт, судалгаа, технологийн салбарын.

2.6.Энэ журмын 2.1-д заасны дагуу нэр дэвшигчийн дараах баримт бичгийг зарласан хугацааны дотор хүлээн авч бүртгэнэ:

2.6.1.кино урлагийг хөгжүүлэх чиглэлийн бодлогыг хэрэгжүүлэх талаар санал, төлөвлөлтийн шийдэл бүхий 3-аас ихгүй хуудас эссэ бичвэр;

2.6.2.анкет, намтар;

2.6.3.иргэний үнэмлэхийн хуулбар;



2.6.4. боловсролын диплом, үнэмлэхийн хуулбар (“Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана);

2.6.5.2 хувь цээж зураг (4х6см хэмжээтэй);

2.6.6. киноны санхүүжилт, кино хөгжүүлэлт, кино зураг авалт, киноны эвлүүлэг, дууны найруулга, кино түгээлтийн болон нэр дэвшсэн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагын талаар нотлох баримт, лавлагаа;

2.6.7. сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, нэр дэвшүүлсэн төрийн бус байгууллагын албан бичиг;

2.6.8. ял шийтгэлтэй эсэх талаарх лавлагаа;

2.6.9. шаардлагатай гэж үзсэн бусад баримт материал.

Гурав. Нэр дэвшигчийг бүртгэх, шалгаруулах

3.1. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг байгуулж, удирдамжийг батална.

3.2. Ажлын хэсгийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын албан хаагч болон кино урлагийн салбарт тодорхой хувь нэмэр оруулж, хүлээн зөвшөөрөгдсөн иргэдээс бүрдсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

3.3. Ажлын хэсгийн гишүүд хөндлөнгийн нөлөөнд автахгүй ажиллах талаар баталгаа гаргаж, сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хурлаар хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэж, тэмдэглэл үйлдэнэ.

3.4. Нэр дэвшигчидтэй холбоотой баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэхийг нягтлан шалгаж дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхгүй:

3.4.1. нэр дэвшихтэй холбоотой материал, баримт бичгийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй;

3.4.2. нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;

3.4.3. заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч.

3.5.Ажлын хэсэг нь удирдамжид заасны дагуу сонгон шалгаруулалтыг баримт бичгийн болон ярилцлагын гэсэн 2 үе шаттайгаар нэр дэвшигчид оноо өгч зохион байгуулна.

3.6.Баримт бичгийн үе шат нь хуульд заасан шалгуураас гадна боловсролын түвшин, мэргэшил, ур чадвар, туршлагыг нарийвчлан тогтоох, эссэ бичвэрийг үнэлэхэд чиглэгдэнэ.

3.7.Нэр дэвшигчийг авсан онооны дарааллаар дүнг гаргаж, энэ журмын 2.5-д заасан чиглэлийн дагуу жагсаана.

3.8.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын дүнг холбогдох баримт бичиг, тайлангийн хамт сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

3.9.Энэ журмыг зөрчсөн нь тогтоогдож тухайн нэр дэвшигчийг томилохоос татгалзсан тохиолдолд дараагийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг нэр дэвшүүлнэ.

3.10.Нэр дэвшигчийг Зөвлөлийн гишүүнээр Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.6-д заасны дагуу соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, чөлөөлнө.

3.11.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвлөлийн даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж, Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.7-д заасны дагуу томилж, чөлөөлнө.

3.12.Зөвлөлийн дарга, гишүүнийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.12-т заасан үндэслэлээр, эсвэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хязгаарлалт зөрчсөн, ашиг сонирхлын зөрчил үүссэн нь тогтоогдсон, эсвэл Зөвлөлийн хуралдааныг хүндэтгэх шалтгаангүйгээр жилд гурваас дээш удаа тасалсан эсхүл Зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох журам зөрчсөн бол хугацаанаас өмнө чөлөөлөх үндэслэл болно.

3.13.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацааг нэг удаа сунгах эсэхийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

3.14.Зөвлөлийн дарга, гишүүн хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---



КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Кино урлагийн зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Кино урлагийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь үйл ажиллагаандаа, Соёлын тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3. Зөвлөл нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.11-д заасны дагуу Ажлын албатай байна.

1.4. Зөвлөл нь зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Зөвлөл өөрийн бэлгэдэлтэй байж болно.

Хоёр. Зөвлөлийн зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан (цаашид “хуралдаан” гэх) байна.

2.2. Хуралдааныг сард 1-ээс доошгүй удаа хийх бөгөөд, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.

2.3. Хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2.4. Зөвлөл нь үйл ажиллагааны чиглэлээр дараах дэд зөвлөлийг байгуулж ажиллана:

2.4.1. Монгол киног дэмжих дэд зөвлөл;

2.4.2. Олон улсын хамтын ажиллагааны дэд зөвлөл;

2.4.3. Олон нийтийн асуудал хариуцсан дэд зөвлөл.

2.5. Зөвлөл нь дарга, гишүүдийг энэ журмын 2.4-т заасан дэд зөвлөлд хуваарилах шийдвэр гаргана.

2.6. Зөвлөлийн дарга, гишүүд нь хоёроос илүүгүй дэд зөвлөлд орж ажиллана.

2.7. Дэд зөвлөл нь энэ журмын 2.8-2.10-т заасан үйл ажиллагааны чиглэлийн дагуу хуралдаанаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцан судалж, холбогдох саналыг боловсруулна.

2.8. Монгол киног дэмжих дэд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл:

2.8.1. кино үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

2.8.2. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12-13 дугаар зүйлд заасны дагуу Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт, зээл олгох арга хэмжээний санал, дүгнэлт гаргах, төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагаас гаргуулан авч, дүгнэлт хийх;

2.8.3. кино үйлдвэрлэлд шаардагдах дэд бүтцийг сайжруулах талаар санал гаргах;

2.8.4. хариуцсан асуудлын хүрээнд хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, зөвлөлд ирсэн өргөдөл, гомдлыг судлан, тайлбар авч, шийдвэрлэх талаар санал гаргах.

2.9. Олон улсын хамтын ажиллагааны дэд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл:

2.9.1. кино бүтээх зардлын тодорхой хувийг буцаан олгох үйл ажиллагаанд холбогдох асуудлаар санал, дүгнэлт гаргах, хяналт тавих;

2.9.2. кино бүтээх зорилгоор гадаадын иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд зөвшөөрөл олгох асуудлаар санал гаргах;

2.9.3. хариуцсан асуудлын хүрээнд хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, зөвлөлд ирсэн өргөдөл, гомдлыг судлан, тайлбар авч, шийдвэрлэх талаар санал гаргах.

2.10. Олон нийтийн асуудал хариуцсан дэд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл:

2.10.1. Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;



2.10.2.кино түгээлтэд баримтлах насны ангилал тогтоох санал гаргах;

2.10.3.мэдээллийн сан, цахим үйлчилгээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар санал гаргах, хяналт тавих;

2.10.4.салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал гаргах;

2.10.5.залуу уран бүтээлчид дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний талаар санал гаргах;

2.10.6.кино архив, кино сурталчилгааны асуудлаар санал, дүгнэлт гарган танилцуулах;

2.10.7.олон улсын кино арга хэмжээнд Монгол киног нэр дэвшүүлэх, оролцуулах талаар санал гаргах;

2.10.8.хариуцсан асуудлын хүрээнд хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, зөвлөлд ирсэн өргөдөл, гомдлыг судлан, тайлбар авч, шийдвэрлэх талаар санал гаргах.

2.11.Зөвлөлийн нарийн бичгийн даргаар зөвлөлийн Ажлын албаны аль нэг нэгжийн даргыг зөвлөлийн даргын санал болгосноор ажиллуулна. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлөөс аливаа шийдвэр гаргахад саналын эрхгүй байна.

2.12.Хуралдааны товыг хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийг хүргүүлсэн байна.

2.13.Хуралдааныг гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд саналыг илээр гаргаж, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.14.Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй бол хуралдааны хэлэлцэх асуудлаар саналаа бичгээр гарган Зөвлөлийн даргад урьдчилан ирүүлснээр түүнийг хуралдаанд оролцсонд тооцно.

2.15.Зөвлөлийн хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Хуралдааны явцад тэмдэглэл хөтөлнө.

2.16.Зөвлөлийн тогтоолд зөвлөлийн дарга болон гишүүд, хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

2.17.Зөвлөлийн гишүүдийн санал, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй гэж үзвэл зөвлөлийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, төсөл, арга хэмжээнээс татгалзсан шалтгааныг холбогдох этгээдэд танилцуулахгүй байж болно.

2.18.Зөвлөл нь мэдээлэл, судалгаа, баримтад үндэслэсэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэр гаргана.

Гурав.Зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүрэг

3.1.Зөвлөлийн дарга нь тус зөвлөл болон түүний Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.кино урлагийн талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.2.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хуралдааныг товлох, зохион байгуулах;

3.1.3.Зөвлөлийг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

3.1.4.Зөвлөлийн Ажлын албаны нэгжийн дарга, ажилтны ажил үүргийн хуваарийг тогтоох, тэдгээрийг томилж, чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх, цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоох;

3.1.5.Зөвлөлийн болон дэд зөвлөлийн хуралдаан зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулахад хяналт тавих, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх;

3.1.6.Зөвлөлийн Ажлын албаны ажилтны мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

3.1.7.Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

3.1.8.иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ, хэлэлцээр байгуулах;

3.1.9.Зөвлөлийн шийдвэрээр олгосон зөвшөөрөлд гарын үсэг зурж баталгаажуулах;

3.1.10.хууль тогтоомж болон энэ журамд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор тушаал, шийдвэр гаргаж, биелэлтийг хангуулах;

3.1.11.Зөвлөлийн төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах;

3.1.12.Зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

3.1.13.ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

3.1.14.хуульд зааснаас бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг хууль тогтоомжийн хүрээнд батлах, мөрдүүлэх;

3.1.15.Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.1.16.хууль тогтоомжид заасан бусад.

3.2.Зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй:

3.2.1.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвлөлийн Ажлын албанд зөвлөлийн даргаар уламжлан үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.2.2.Зөвлөлийн хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхээр санал оруулах;

3.2.3.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах;

3.2.4.Зөвлөлийн хурлаас шийдвэрлэсний дагуу энэ журмын 2.4-т заасан дэд зөвлөлд харьяалагдан, санал дүгнэлт гаргаж, зөвлөлийн болон дэд зөвлөлийн хуралд таслах эрхтэй оролцох;

3.2.5.хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэх, санал хураалтад оролцохоос татгалзах;

3.2.6.Зөвлөл, дэд зөвлөлийн хуралдааны дэгийг чанд сахиж, ажиллах;

3.2.7.байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг задруулахгүй байх;

3.2.8.Зөвлөлөөс албан ёсоор мэдээлснээс бусад асуудлаар мэдээлэл хийхгүй байх.

3.3.Зөвлөлийн даргын түр эзгүйд түүний зөвшөөрснөөр хуралдааныг насаар хамгийн ахмад зөвлөлийн гишүүн даргална.

3.4.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.12-т заасны дагуу дуусгавар болсон тохиолдолд зөвлөлийн гишүүнийг нөхөн томилно. Нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

3.5.Зөвлөлийн гишүүнд хуралдаанд оролцсон байдлаас хамаарч урамшуулал олгоно. Зөвлөлийн гишүүний урамшууллын хэмжээг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр зөвлөл батална.

Дөрөв.Зөвлөлийн бүрэн эрх

4.1.Зөвлөл нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.16-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Зөвлөлийн стратеги төлөвлөгөө боловсруулан, хэлэлцэж соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх, батлагдсан төсөв, стратегийн хүрээнд зөвлөлийн Ажлын албаны нэгжийн чиг үүргийг батлах;

4.1.2.Зөвлөлийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;

4.1.3.Зөвлөлийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, зааврыг баталж, биелэлтэд нь хяналт тавих;

4.1.4.шаардлагатай тохиолдолд гадаад, дотоодын мэргэшсэн судлаач, шинжээч ажиллуулах;

4.1.5.кино урлагийн салбарын мэдээллийн систем, программ хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглалт хэрэглээг дэмжих, тогтвортой ажиллагааг хангах;



4.1.6.Зөвлөлийн үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах, холбогдох журмыг батлах;

4.1.7.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12.1, 15.1, 20.1-д тус тус заасан дэмжлэг, зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох бусад этгээдээс тайлан, мэдээ, мэдээлэл, тодорхойлолт гаргуулан авах;

4.1.8.кино урлагийн салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;

4.1.9.кино үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн болон холбогдох бусад стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;

4.1.10.кино үйлдвэрлэлтэй холбоотой бусад асуудал.

Тав.Бусад зүйл

5.1.Зөвлөл түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсөв, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.2.Зөвлөл нь монгол, англи хэлээр өөрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай мэдээллийг харуулсан албан ёсны цахим систем, хуудастай байна.

5.3.Зөвлөлийн дарга, гишүүд энэ журмыг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Засгийн газрын 2022 оны 90 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Кино урлагийн зөвлөлийн Ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-ны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2.Ажлын алба нь Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

1.3.Ажлын алба нь дараах зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна:

1.3.1.Монгол киног дэмжих нэгж;

1.3.2.Олон улсын хамтын ажиллагааны нэгж;

1.3.3.Олон нийтийн асуудал хариуцсан нэгж;

1.3.4.Захиргаа, санхүүгийн нэгж.

1.4.Ажлын алба нь Соёлын тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэ дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

1.5.Кино урлагийн зөвлөлийн дарга нь Ажлын албаны дарга байх бөгөөд төрийн үйлчилгээний албан тушаалтан байна.

1.6.Ажлын албаны дарга нь эрхлэх асуудлын хүрээнд тушаал гаргана.

1.7.Ажлын албаны дарга тухайн төсвийн жилд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй гэрээ байгуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллана.

Хоёр.Ажлын албаны чиг үүрэг

2.1.Ажлын алба дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах;

2.1.2.холбогдох байгууллага, Зөвлөлийг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах;

2.1.3.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20.1-д заасан зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж, санал, дүгнэлт гаргах;

2.1.4.Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох баримт бичгийн төсөл боловсруулах;

2.1.5.Ажлын албаны хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;



2.1.6.Зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх;

2.1.7.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн ерөнхий нөхцөл, хамрах хүрээ, тавигдах шаардлага, мэдүүлэг гаргах зааварчилгаа бэлтгэх, мэдээлэл, зөвлөмж боловсруулах;

2.1.8.соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;

2.1.9.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан Кино урлагийн мэдээллийн сангаар дамжуулан кино урлагийн үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг түгээх, сурталчлах;

2.1.10.салбарын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад мэргэжлийн төрийн бус байгууллага, уран бүтээлчийн саналыг авах ажлыг зохион байгуулах;

2.1.11.холбогдох хууль, журмын дагуу Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийг тайлагнах;

2.1.12.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.2.Ажлын албаны нэгжийн чиг үүргийг Зөвлөлөөс тогтооно.

Гурав.Бусад

3.1.Ажлын албаны өмч, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт болон энэ дүрэмд зааснаас бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулж, хяналт тавьж ажиллана.

3.2.Зөвлөлийн дарга байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг холбогдох удирдах дээд байгууллагын өмнө хариуцна.

3.3.Ажлын алба нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох журам, зааврын дагуу дараах баримт бичгийг хадгална:

3.3.1.Зөвлөл болон ажлын албаны үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, холбогдох шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ;



3.3.2.Зөвлөлөөс гаргасан бүхий л шийдвэр, түүнд хамаарах баримт;

3.3.3.Зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан болон төлөвлөгөө, гэрээ;

3.3.4.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, нягтлан бодох бүртгэлд тусгасан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг, аудитын дүгнэлт, зөвлөмж;

3.3.5.Зөвлөлийн даргын тушаал, албан бичиг, хуралдааны тэмдэглэл, шийдвэр;

3.3.6.байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад орсон бусад баримт бичиг.

3.4.Ажлын албаны дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Дүрэмд хуульд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

3.5.Ажлын албаны албан хаагчийн хууль зөрчсөн үйлдэлд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Малын генетик нөөцийн тухай хуулийн 13.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт бүхий мал, амьтныг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.



3. Энэ журмын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

З.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 2022 оны 92 дугаар
тогтоолын хавсралт

**ТӨРӨЛ БҮРИЙН ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛЫГ ҮРЖҮҮЛЭХ БҮС,
БАЙРШЛЫГ ТОГТООХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсад үржүүлж буй төрөл бүрийн үүлдэр, омгийн малын ашиг шимийн чиглэл, цөм сүргийн байршил, үржүүлэх зохистой бүс нутгийг тогтооход энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмын зорилго нь Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омог болон гадаадаас авчирч нутагшуулан үржүүлж буй өндөр ашиг шимт малыг дасан зохицсон, ашиг шимээ бүрэн өгөх, хэвийн өсөж үржих боломжтой бүс нутагт нь сонгон үржүүлэх, сайжруулагчаар ашиглах, генетик нөөцийг хадгалж, хамгаалах замаар мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, эдийн засгийн ач холбогдол бүхий мал сүргийг өсгөн үржүүлэх, мал аж ахуйн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэгдэнэ.

1.3.Энэ журам нь Монгол Улсад мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, ашиг шимийг нь хүртэж буй этгээдэд адил хамаарна.

Хоёр.Хэрэгжилтийг зохион байгуулах

2.1.Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тэдгээрийн дасан зохицсон, ашиг шимээ бүрэн өгөх, хэвийн өсөж үржих боломжтой бүс нутгаар нь Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омог болон гадаад улсаас импортолж нутагшуулан үржүүлж буй өндөр ашиг шимт мал гэсэн ангиллаар малын төрөл, үүлдэр, омог тус бүрд тогтооно.

2.2.Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох саналыг тухайн төрлийн үүлдэр, омгийн малын биологийн

онцлог, арчилгаа, маллагааны технологи, ашиг шимийн чиглэл, хянан баталгаажуулсан шийдвэр, цөм сүргийн байршил, цаашид үржүүлэх тохиромжтой бүс нутгийн талаар судлаач, зохион бүтээгч, хамтран оролцогчдын хийсэн судалгаа, санал, хүсэлтэд үндэслэн Малын үүлдэр, ашиг шимийн зөвлөл гаргана.

2.3.Малын үүлдэр, ашиг шимийн зөвлөлийн гаргасан саналыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны хуралдаанаар хэлэлцэж, энэ журамд заасан зорилго, ангилал, шаардлагад нийцүүлэн тогтоосон, төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг баталгаажуулах тухай зөвлөмжийг гаргана.

2.4.Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.3-т заасан зөвлөмжийн дагуу төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох шийдвэрийг гаргана.

2.5.Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омгийн малын цөм сүргийг үржүүлэх бүс, байршлыг үүлдэр, омгийн тодорхойлолт, зохион бүтээгч, хамтран оролцогчдын санал, үржлийн ажлын стратеги төлөвлөгөөнд тулгуурлан анх өвөрмөц шинж байдлаа олж авсан, хадгалж ирсэн орчин зүйн бүрдэлд буюу уугуул орчинд нь тогтоож хадгалж хамгаална.

2.6.Гадаад улсаас импортолж нутагшуулан үржүүлж буй өндөр ашиг шимт үүлдэр, тэдгээрийг ашиглан гаргаж авсан үржлийн малыг шилжүүлж дасгасан орчин зүйн бүрдэлд буюу нутагшуулан үржүүлэх боломжит бүс, байршилд цэврээр нь сонгон үржүүлэх замаар генетикийн нөөцийг ашиглаж, хадгалж хамгаална.

2.7.Тоо, тархалтын хувьд доройтолд орсон болон арчилгаа маллагааны онцгой нөхцөл шаардах үүлдэр, омгийг анх батлагдсан орчинд нь өсгөж үржүүлэх чиглэлийг баримталж биотехнологийн дэвшилтэт аргыг ашиглан сайжруулах замаар генетик нөөцийг хадгалж хамгаална.

2.8.Судалгаа, шинжилгээ, туршилтын явцад үр дүн нь батлагдаж, шинээр хянан баталгаажсан үүлдэр, омог, өндөр ашиг шимт импортын малын ашиг шимийн чиглэл, онцлогийг харгалзан боломжит бүс, байршилд үржүүлж, генетикийн нөөцийг ашиглаж, хадгалж хамгаална.

2.9.Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт, ашиглалт бүхий тэмээ, сарлаг, цаа буга зэрэг мал, амьтан түүний төрөл, зүйлийг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээг энэ журамд нийцүүлэн орон нутгийн мэргэжлийн байгууллага хэрэгжүүлнэ.



2.10. Үүлдэр, омгийн малыг үржлийн зориулалтаар бойжуулах, худалдан борлуулах, шилжүүлэх үйл ажиллагааг тогтоосон бүс, байршилд нийцүүлэн эрхлэх бөгөөд тухайн мал нь цөм сүргийн стандарт, шаардлагыг бүрэн хангасан, ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, удам гарваль нь баталгаажсан байна.

2.11. Малын үүлдэрлэг байдал алдагдах, тоо толгой цөөрөх, устаж мөхөх эрсдэлээс сэргийлэх, хамгаалах зорилгоор үүлдэр, омгийн малаас үр авах, дээж, сорьц, цуглуулгыг бий болгох, тусгай орчинд хадгалж, хамгаалах, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх, үржүүлэгт ашиглах асуудлыг малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага хэрэгжүүлнэ.

2.12. Энэ журмын хэрэгжилтийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн бүх шатны мэргэжлийн байгууллага чиг үүргийн хүрээнд хариуцан зохион байгуулна.

Гурав.Хэрэгжилтэд хяналт тавих

3.1. Аймаг, нийслэлд малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасаг энэ журмын хэрэгжилтэд технологийн хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.2. Журмын хэрэгжилтийг хангуулах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах асуудлыг бүх шатны мэргэжлийн хяналтын байгууллага, мал үржлийн хяналтын улсын байцаагчид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

-----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 9-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6.5, 9.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.



2.Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгоход шаардагдах зардлыг жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа даалгасугай.

3.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам, тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 513 дугаар тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 74 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

А.АРИУНЗАЯА

Засгийн газрын 2022 оны 97 дугаар
тогтоолын хавсралт

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хүүхэд харах үйлчилгээнд олгох санхүүгийн дэмжлэг (цаашид “санхүүгийн дэмжлэг” гэх)-ийн хэмжээг тооцож төлөвлөх, түүнийг хуваарилах, олгох, зарцуулалтад нь хяналт тавихад энэ журмыг мөрдөнө.

1.2.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоо таваас илүүгүй байна.

1.3.Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дагнан хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо гурваас илүүгүй байна.

1.4.Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхэдтэй хамт хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэг байна.



1.5. Хүүхэд харагч нь сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

1.6. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхэд нь цэцэрлэгт давхар хамрагдаагүй буюу “Боловсролын салбарын мэдээллийн систем”-д бүртгэгдээгүй байна.

Хоёр. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцох, төлөвлөх

2.1. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцож төлөвлөхөд Засгийн газраас баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив” болон найман цагаар ажилладаг цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг тогтоосон нормативыг мөрдөнө.

2.2. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ногдох хувьсах зардлыг тооцохдоо “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ыг 2 дахин нэмэгдүүлж тооцно.

2.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг мэдээллийн сан дахь хүүхдийн тоо, хяналт үнэлгээний дүнд үндэслэн тооцож төлөвлөн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.3-т заасан саналыг хянан нэгтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналд тусган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зохих журмын дагуу хүргүүлнэ.

Гурав. Хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн сан, мэдээ, хяналт

3.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн сантай байна. Мэдээллийн санд дараах мэдээллийг багтаана:

3.1.1. Хүүхэд харагчийн талаарх мэдээлэл:

а) овог, эцэг (эх)-ийн нэр, нэр, харьяалал;

б) регистрийн дугаар;
в) боловсролын түвшинг нотлох баримт бичгийн дугаар, огноо;

г) хүүхэд харах үйлчилгээний сургалтад хамрагдсаныг нотлох баримт бичгийн дугаар, огноо;

д) хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрөл олгосон сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийн дугаар, огноо;

е) хүүхэд харах үйлчилгээ эрхлэх байрны хаяг, хүүхэд харах үйлчилгээний стандартыг хангаж байгааг нотлон олгосон зөвшөөрлийн дугаар, огноо;

ж) холбоо барих утасны дугаар, харилцах банкны төгрөгийн данс.

3.1.2. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн талаарх мэдээлэл:

а) овог, эцэг, эхийн нэр, нэр;

б) эцэг, эх, хүүхдийн регистрийн дугаар;

в) холбоо барих утасны дугаар;

г) хүүхдийн оршин суух хаяг;

д) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийн дугаар, огноо.

3.2. Хүүхэд харагч нь тухайн сард хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, ирцийн бүртгэлийн мэдээ (цаашид “мэдээ” гэх)-г хүүхдийн овог, нэр, регистрийн дугаараар гаргаж, дараа сарын 5-ны дотор дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сумын Засаг даргын Тамгын газарт цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.3. Сумын Засаг даргын Тамгын газар мэдээг нэгтгэж, тухайн сарын 10-ны дотор аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.4. Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээг мөн журмын 3.1-д заасан мэдээллийн сангай тулган хянаж, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн сарын 15-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.5. Энэ журмын 3.2-т заасан мэдээний маягтыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

3.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын талаар зөвлөмж, аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.7. Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн давхардлыг улиралд нэгээс доошгүй удаа шалгана.

3.8. Хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн сан, олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Санхүүгийн дэмжлэгийг олгох, хуваарилах

4.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүгийн дэмжлэгийг хичээлийн жилд багтаан шилжүүлж дууссан байхаар тооцож, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төсвийн сар, улирлын хуваарийг батална.

4.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу ирүүлсэн мэдээнд үндэслэн аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

4.3. Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээ зөрчилгүй байгаа тохиолдолд сар бүрийн 30-ны дотор хүүхэд харагчийн харилцах банкны төгрөгийн дансанд санхүүжилтийг шилжүүлнэ.

Тав. Бусад

5.1. Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар болон мэргэжлийн хяналтын байгууллага нь энэ журамд заасан хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй хүүхэд харагчид олгох санхүүгийн дэмжлэгийг зогсоох, зөвшөөрлийг хүчингүй болгох санал, дүгнэлтийг зөвшөөрөл олгосон этгээдэд хүргүүлж шийдвэрлүүлнэ.



5.2.Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийг хүүхэд харах үйлчилгээний бүртгэлд оруулж, хуурамч мэдээ өгсөн хүүхэд харагч болон сарын мэдээг буруу мэдүүлсэн албан тушаалтанд Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйл болон Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Боловсролын тухай хуулийн 43.2.10, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ, хугацаа”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэгт шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 44 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 133 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсад мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв (цаашид “Сургалтын байгууллага” гэх)-ийн суралцагчийг урамшуулах, гарааны бизнес эхлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дараагийн түвшинд шатлан суралцах, сургалтын чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор суралцагчийг төгсөхөд тэтгэлэг нэг удаа олгоход энэ журмыг баримтална.

1.2.Сургалтын байгууллагад анх удаа мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын 2.5 жил, 1 жилийн өдрийн анги, техникийн боловсрол эзэмшүүлэх 3 жилийн өдрийн ангийн хөтөлбөрийг судалж, тэтгэлэг авах шаардлага хангасан 45 хүртэлх насны суралцагчид төгсөхөд нь тэтгэлгийг нэг удаа олгоно.

1.3.Мэргэжлийн боловсрол эзэмшиж, техникийн боловсролын 1.5 жилийн сургалтад үргэлжлүүлэн шатлан суралцаж байгаа энэ журмын 1.2-т заасан шаардлага хангасан төгсөгчид тэтгэлэг олгоно.

Хоёр.Тэтгэлэг олгох нөхцөл

2.1.Сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.1.2.мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан элсэлтийн хяналтын тоо, мэргэжлийн чиглэлийн дагуу элсэлт зохион байгуулсан байх;

2.1.3.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байх;

2.1.4.цахим мэдээллийн санд статистик тоо мэдээллийг хугацаанд нь ирүүлсэн байх;

2.1.5.тэтгэлэг авах болзол хангасан суралцагчийн ирц болон бусад холбогдох мэдээллийг бүрдүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төгсөх улиралд нь багтаан ирүүлсэн байх.

2.2.Суралцагч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.онол, дадлагын сургалтад 80-аас дээш хувийн ирцтэй хамрагдсан байх;

2.2.2.хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаан (эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт)-ы улмаас сургалтад хамрагдаагүй нь чөлөөний хуудас, эмчийн магадалгаагаар тодорхойлогдож, ирцийг тооцуулсан байх;

2.2.3.ёс зүйн дүрмийн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх;

2.2.4.нэгдсэн системд бүртгэгдсэн байх.

2.3.Дараах суралцагчид тэтгэлэг олгохгүй:

2.3.1.байгууллагад ажил эрхэлж, албан журмын нийгмийн даатгалд хамрагдаж шимтгэл төлдөг;

2.3.2.суралцаж байх хугацаандаа гэмт хэрэг, зөрчилд холбогдож шийтгүүлсэн;

2.3.3.хүндэтгэн үзэх шалтгаангүй хичээл, сургалтаа орхисон.

2.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17.1.2-т заасны дагуу суралцагч үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ хөдөлмөрийн хөлс авсан, эсхүл сайн дурын нийгмийн даатгал төлдөг тохиолдолд энэ журмын 2.3.1 дэх заалт хамаарахгүй.

Гурав.Суралцагчид олгох тэтгэлгийн санхүүжилт

3.1.Боловсролын тухай хуулийн 43.2.10, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21.1-д заасны дагуу суралцагчид олгох тэтгэлгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

3.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас суралцагчийн ирц болон бусад холбогдох



мэдээллийг үндэслэн тухайн хичээлийн жилд багтаан суралцагчийн банканд дахь харилцах дансанд тэтгэлгийг шилжүүлнэ.

Дөрөв.Хяналт, хариуцлага

4.1.Энэ журмын хэрэгжилтэд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж хяналт тавина.

4.2.Тэтгэлэг давхардуулан олгосон, энэ журмын 1.2-т заасан суралцагчид хуурамчаар бичиг баримт бүрдүүлэн тэтгэлэг олгосон нь тогтоогдвол сургалтын байгууллагын удирдлага, уг асуудлыг хариуцсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.3.Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системд суралцагчийн мэдээлэл, ирц, үнэлгээний голч дүнг буруу, эсхүл хуурамчаар тооцож оруулсан, хугацаанд нь баталгаажуулаагүйн улмаас төгсөхөд нь тэтгэлэг олгогдоогүй бол буруутай этгээдээр хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, хохирлыг нөхөн төлүүлнэ. (Энэ заалтыг 2022-2023 оны хичээлийн жилээс эхэлж мөрдөнө.)

---о0о---

Засгийн газрын 2022 оны 122 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД ОЛГОХ ТЭТГЭЛГИЙН ХЭМЖЭЭ, ХУГАЦАА

Сургалтын чиглэл	Сургалтын хугацаа	Суралцагчийн суралцах хугацаа	Тэтгэлгийн сарын хэмжээ	Нийт олгох тэтгэлгийн хэмжээ
	жилээр	сараар	төгрөгөөр	
Мэргэжлийн боловсрол олгох	1	10	200,000	2,000,000
	2,5	25	200,000	5,000,000
Техникийн боловсрол олгох	1,5	15	200,000	3,000,000
	3	30	200,000	6,000,000

Жич: 2021-2022 оны хичээлийн жилд суралцаж байгаа суралцагчид тэтгэлэг олгохдоо 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төгсөх хүртэл хугацаагаар дүйцүүлэн сар бүр 200,000 (хоёр зуун мянган) төгрөгөөр тооцон төгсөхөд нэг удаа олгоно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 132 дугаар
тогтоолын хавсралт

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС САНХҮҮЖИЛТ ОЛГОХ БОЛОН БАНКАНД ТАВИХ ШАЛГУУР, БАНКИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ, ЭРГЭН ТӨЛӨХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.9-д заасан кино бүтээх үйл ажиллагааг төрөөс дэмжих зориулалт бүхий Кино урлагийг дэмжих сан (цаашид “сан” гэх)-аас эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилт олгох болон эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл олгох, зээл олгох банкийг сонгон шалгаруулах, зээлийг эргэн төлөх, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сангийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт, түүнд хяналт тавих үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль, Соёлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.



1.3.Сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1-д заасан улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламж, тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн хүүгийн орлогын эх үүсвэрээс бүрдэх бөгөөд сангийн хөрөнгийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн хуулийн 13.1, 13.2-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулна.

1.4.Сангаас дараах тохиолдолд дэмжлэг үзүүлэхгүй:

1.4.1.төсөл, арга хэмжээ нь хүчирхийлэл, түрэмгийлэл, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг илт сурталчилсан;

1.4.2.сангаас өмнө нь санхүүгийн дэмжлэг авсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

1.4.3.сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;

1.4.4.сангаас олгосон санхүүжилтээр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа;

1.4.5.зээл авах этгээд нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;

1.4.6.төсөл, арга хэмжээ болон түүнийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрөөгүй;

1.4.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд зарцуулсан зардлын тодорхой хувийг буцаан авах талаар хүсэлт гаргасан, гэрчилгээ авсан, гэрээ байгуулсан;

1.4.8.сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;

1.4.9.төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

1.5.Сангаас кино бүтээх төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхэд дараах нөхцөлийг харгалзана:

1.5.1.монгол кино бүтээх төсөл, эсхүл Монгол Улсын кино продюсер нийт санхүүжилтийн 50-аас доошгүй хувийг нь санхүүжүүлэх хамтарсан кино бүтээх төсөл;

1.5.2.үргэлжлэх хугацаа нь 75 минутаас доошгүй байх уран сайхны болон анимейшн кино бүтээх;

1.5.3.үргэлжлэх хугацаа нь 60 минутаас доошгүй байх баримтат уран сайхны кино бүтээх.

Хоёр.Сангийн хөрөнгийн санхүүжилтийн хувь, хэмжээ

2.1.Сангийн хөрөнгийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12.2.1 болон 12.2.2-т заасан санхүүжилтийн хэлбэрт тэнцүү хуваарилж дэмжлэг үзүүлнэ.

2.2.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1-д заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хувь, хэмжээг энэ журмын 2.1-д заасныг баримтлан дараах байдлаар соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр тогтооно:

2.2.1.кино бүтээх дор дурдсан төсөл, арга хэмжээ:

2.2.1.1.Монголын түүхийг харуулах олон ангит кино, уран сайхны кино, баримтат кино;

2.2.1.2.хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшилд эергээр нөлөөлөх олон ангит кино, уран сайхны кино, баримтат кино, анимейшн кино, эсхүл нийгмийн эрүүл мэнд, эрүүл, зөв амьдрах дадал зуршил хэвшүүлэхэд эергээр нөлөөлөх баримтат кино;

2.2.1.3.олон улсын кино наадамд өрсөлдөх зорилготой найруулагчийн хувийн бүтээлч чанар, гоо зүйн үнэлэмж, үзэл бодлын илэрхийллийг харуулах уран сайхны кино болон богино хэмжээний кино (Артхаус кино);

2.2.1.4.Монголын соёл, ахуй амьдралыг харуулах кино, эсхүл залуу кино найруулагчийн анхны болон хоёр дахь уран сайхны кино, богино хэмжээний кино;

2.2.2.монгол киног хадгалах, сэргээн хөрвүүлэх;

2.2.3.олон улсын кино наадам, үзэсгэлэнд монгол киногоор оролцох, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулах, төрөөс гадаадад монгол кино урлагийг сурталчлах, кино наадамд оролцох;

2.2.4.кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

2.3.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.2-т заасан дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгох зээлийг сонгон шалгарсан арилжааны банкаар дамжуулан олгоно:

2.3.1. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1.1-д зааснаас бусад кино бүтээх;

2.3.2. кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэх.

2.4. Энэ журмын 2.2.1-д заасан кино бүтээх төсөл, арга хэмжээнд дараах үе шатанд дэмжлэг үзүүлнэ:

2.4.1. кино төсөл боловсруулах, хөгжүүлэх буюу кино зохиолын товч агуулга болон кино төслийн танилцуулгын дизайн, хэвлэл, кино зохиол бичих, кино төсөл боловсруулах сургалт болон кино төслийн олон улсын танилцуулах сургалт, хөтөлбөрт хамрагдах, хөтөлбөрт оролцох, кино зохиолын олон улсын зөвлөх ажиллуулах, кино зохиолын хэсэгчилсэн туршилтын зураг авалт хийх;

2.4.2. зураг авалт, эвлүүлэг, дуу, дүрсний найруулга хийх;

2.4.3. киног олон нийтэд хүргэх бэлтгэл ажлыг гүйцэтгэх буюу киног гадаадад гаргахтай холбоотой сурталчилгааны зардал, кинотеатрт түгээхэд тавигдах үндсэн форматад хувиргах (DCP).

Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.5-д зааснаар соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан удирдана.

3.2. Энэ журмын 2.2, 2.3-т заасан төсөл, арга хэмжээнд Сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилт болон эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл олгох шийдвэрийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.16.5-д заасны дагуу Кино урлагийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн санал, дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана. Зөвлөлийн санал, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд гадаадын шинжээч, мэргэжилтнийг оролцуулж болно.

3.3. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Зөвлөлийн Ажлын алба хэрэгжүүлнэ.

3.4. Зөвлөл нь санхүүжилт болон зээл хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлтийг жилд 2-оос доошгүй удаа цахим хэлбэрээр хүлээн авна. Хүсэлт хүлээн авах товыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох бөгөөд олон нийтэд зарлах ажлыг Зөвлөл зохион

байгуулна. Тухайн төсвийн жилд санхүүжилт болон зээл олгох төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах эхний зарыг төсөв батлагдсанаас хойш ажлын 20 хоногийн дотор зарлах арга хэмжээ авна.

3.5.Энэ журмын 3.4-т заасан соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон хугацаанд техникийн саатал гарч, хүсэлт хүлээн авах боломжгүй болсон тохиолдолд хүсэлт хүлээн авах хугацааг техникийн сааталтай байсан хугацаагаар хойшлуулна.

3.6.Зөвлөл санхүүжилт болон зээл хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлтийг эрсдэлийн үнэлгээний арга, аргачлалд суурилан үнэлэх зарчмыг баримтлах бөгөөд уг арга, аргачлалыг Зөвлөл батална.

3.7.Зөвлөлийн дарга, гишүүн хуралдааны шийдвэрээс бусад зөвлөлдсөн асуудлын талаарх мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

3.8.Зөвлөл сангаас дэмжлэг олгохыг хүссэн хүсэлт хүлээн авах, бүртгэхтэй холбоотой маягт, загвар, зааврыг баталж, цахим хуудсанд байршуулна.

**Дөрөв.Сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилт
авах төсөл, арга хэмжээний хүсэлт гаргах,
бүрдүүлэх материал**

4.1.Сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1.1-13.1.4-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно.

4.2.Энэ журмын 4.1-д заасан дэмжлэг авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд дор дурдсанаас гадна хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээсээ хамаарч мөн журмын 4.3-4.6-д заасан баримт бичиг, материалыг бүрдүүлэн журмын 3.4-т заасан хугацаанд Зөвлөлд хүсэлтээ гаргана:

4.2.1.өргөдөл (төсөл, арга хэмжээний товч агуулга, ач холбогдлыг тусгасан байх);

4.2.2.иргэн, хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг, иргэний регистрийн дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.2.3.үйл ажиллагаа явуулж буй хаяг, байршил;

4.2.4.хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжилтийн хуваарь, түүнээс өөрийн оруулах



хөрөнгийн хэмжээг нотолсон, эсхүл банкны холбогдох баримт болон сангаас хүссэн санхүүжилтийн хэмжээ;

4.2.5.одоо эрхэлж байгаа үйл ажиллагаа, бизнесийн талаарх мэдээлэл;

4.2.6.төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны хуваарь, төслийн багийн мэдээлэл.

4.3.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1.1-д заасан киног бүтээхэд санхүүжилт авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд энэ журмын 4.2-т зааснаас гадна дараах баримт бичиг, материалыг бүрдүүлнэ:

4.3.1.кино төслийн үзэл баримтлал, зохиолын хураангуй хувилбар, кино бүтээх төслийн хураангуй танилцуулга;

4.3.2.кино продюсер, найруулагчийн ур чадвар, туршлага, уран бүтээлийн амжилтын мэдээлэл;

4.3.3.санхүүгийн тооцоо (кино төсөл боловсруулах, зураг авалт хийх, эвлүүлэг, дуу, дүрсний найруулга хийх, кино түгээх эхний үзвэрийн хуулбарыг үйлдвэрлэх болон бусад материалтай холбоотой зардал), санхүүжилт бүрдүүлэх төлөвлөгөө, багийн танилцуулга, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн;

4.3.4.оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбогдох баримт бичиг, гэрээ.

4.4.Монгол киног хадгалах, сэргээн хөрвүүлэхэд санхүүжилт авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд энэ журмын 4.2-т зааснаас гадна тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч талуудын ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, санхүүгийн тооцоолол, үр дүн, оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой баримт бичиг, материалыг бүрдүүлнэ.

4.5.Олон улсын кино наадам, үзэсгэлэнд монгол киногоор оролцох, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулахад санхүүжилт авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд энэ журмын 4.2-т зааснаас гадна төсөл, арга хэмжээнээс хамаарч дараах баримт бичиг, материалыг бүрдүүлнэ:

4.5.1.кино наадамд оролцохыг нотолсон баримт бичиг (урилга, оролцох наадмын нэр, бүртгэлийн дугаар, оролцогч орон, оролцох уран бүтээлийн танилцуулга болон бүтээлийг гадаад хэл рүү хөврүүлсэн хувь бэлтгэх, зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн туршлагын мэдээлэл), зардлын тооцоо, үр дүнг багтаасан төслийн баримт бичиг;

4.5.2. олон улсын кино наадам зохион байгуулах туршлага, зохион байгуулж байсан наадмын талаарх мэдээлэл;

4.5.3. кино наадам зохион байгуулах зардлын тооцоо, үр дүн, оролцогч тал, хамтран ажиллах байгууллагын мэдээлэл зэргийг багтаасан төслийн баримт бичиг.

4.6. Кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад санхүүжилт авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд энэ журмын 4.2-т зааснаас гадна төсөл, арга хэмжээнээс хамаарч дараах баримт бичиг, материалыг бүрдүүлнэ:

4.6.1. суралцах сургууль, мэргэжил, мэргэшил дээшлүүлэх байгууллагын танилцуулга, сургалтын төлөвлөгөө, санхүүгийн тооцоолол, гадаад хэлний мэдлэгийн түвшнийг тодорхойлох баримт зэргийг багтаасан баримт бичиг, холбогдох материал;

4.6.2. зохион байгуулах арга хэмжээ, сургалт, форум, семинарын хөтөлбөр, зохион байгуулагч, багшлах этгээдийн туршлагын мэдээлэл, сургалт, арга хэмжээнд оролцогчийн мэдээлэл, санхүүгийн тооцоолол, хүрэх үр дүн болон бусад холбогдох мэдээллийг багтаасан төслийн баримт бичиг;

4.6.3. гадаадын мэргэжилтэн урьж ажиллуулах, туршлага судлах зорилгоор төсөл хэрэгжүүлэх бол тухайн төслийг хэрэгжүүлэгч талуудын харьяалагдах байгууллагын мэдээлэл, мэргэжилтний мэргэжлийн туршлага болон Монгол Улсад хийх ажлын төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн зэргийг багтаасан төслийн баримт бичиг;

4.6.4. сургуульд элсэх болзол хангасан, эсхүл суралцаж байгааг нотолсон баримт бичиг.

4.7. Энэ журмын 4.2-т заасан иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнийхээ нийт санхүүжилтийн 30-аас доошгүй хувийг хүсэлт гаргах үедээ шийдвэрлэсэн байна.

4.8. Энэ журмын 4.2-т заасан иргэн, хуулийн этгээд хүсэлтдээ хавсаргах гадаад хэл дээрх эх баримт бичгийг орчуулгын хамт ирүүлнэ. Баримт бичиг, материалын үнэн зөв байдлыг хүсэлт гаргагч бүрэн хариуцах ба шалгаруулалтын явцад шаардлагатай бусад баримт бичгийг нэмэлтээр бүрдүүлэх боломжтой байна.

4.9. Нэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжилт олгохыг хүссэн хүсэлтийг гурваас дээш удаа мэдүүлэхгүй.

4.10. Төсөл, арга хэмжээ нь хүсэлтэд заасан хугацаандаа хэрэгжих боломжтой байхаас гадна сангаас авах санхүүжилтийн 30-аас доошгүй хувийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зарцуулахаар төлөвлөсөн байна.



Тав.Эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилт олгох төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгон шалгаруулах

5.1.Зөвлөл санхүүжилт хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 45 хоногт багтаан хуралдаж хүсэлтийг хэлэлцэн төсөл, арга хэмжээг үнэлэн сонгон шалгаруулж, санал, дүгнэлт гаргаж соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

5.2.Зөвлөл санхүүжилтийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тооцож, дүгнэлт гаргана:

5.2.1.залуу кино найруулагч анхны болон хоёр дахь уран сайхны кино, уран сайхны богино хэмжээний кино бүтээхэд нь нийт санхүүжилтийн 80 хүртэлх хувийн;

5.2.2.энэ журмын 5.2.1-д зааснаас бусад кино бүтээхэд нийт санхүүжилтийн 70 хүртэлх хувийн дэмжлэг үзүүлэх ба хамтарсан кино бүтээхэд Монгол Улсын кино продюсерын санхүүжүүлэх зардлын 30 хүртэлх хувийн, найруулагчийн хувийн бүтээлч чанар, гоо зүйн үнэлэмж, үзэл бодлын илэрхийллийг харуулсан кино (артхаус кино) хамтран бүтээх бол Монголын Улсын кино продюсерын санхүүжүүлэх зардлын 50 хүртэлх хувийн;

5.2.3.олон улсын кино наадам, үзэсгэлэнд монгол киногоор оролцох, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулах, монгол кино хадгалах, сэргээн хөрвүүлэх, кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад 80 хүртэлх хувийн.

5.3.Зөвлөл нь санхүүжилт хүссэн кино бүтээх төсөл, арга хэмжээг бодитой, хэрэгжих боломжтой, үр дүнтэй гэж тооцсон бол киноны бүтэн зохиолтой танилцах, шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авах болон хүсэлт гаргагч этгээдтэй ярилцлага зохион байгуулж болно. Найруулагчийн хувийн бүтээлч чанар, гоо зүйн үнэлэмж, үзэл бодлын илэрхийллийг харуулсан кино (артхаус кино) болон шаардлагатай бусад кино төсөлд гадаадын болон дотоодын зөвлөх, шинжээч ажиллуулж болно.

Зургаа.Эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилт олгох гэрээ байгуулах, санхүүжилт олгох

6.1.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 5.1-д заасан санал, дүгнэлтийг үндэслэн эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилт олгох шийдвэрийг гаргана.

6.2.Зөвлөл энэ журмын 6.1-д заасан шийдвэрийг үндэслэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулна.

6.3.Энэ журмын 6.2-т заасан гэрээнд дараах зүйлсийг тусгана:

6.3.1.үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан ирүүлэх хугацаа;

6.3.2.төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх болон санхүүжүүлэх хуваарь, олгосон санхүүжилтийг зарцуулах үйл ажиллагаа, арга хэмжээ;

6.3.3.төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, биелэлт, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх хугацаа;

6.3.4.төсөл, арга хэмжээний хэрэгжих явцын хяналтын хуваарь;

6.3.5.гэрээнээс татгалзах, гэрээ цуцлах нөхцөл, гэрээг зөрчсөнөөс үүсэх хариуцлага, олгосон санхүүжилтийг нөхөн төлүүлэх болон хохирол арилгуулах нөхцөл.

6.4.Зөвлөл энэ журмын 6.1-д заасан санхүүжилтийг 6.2-т заасан гэрээний дагуу олгоно.

Долоо.Эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл

7.1.Сангаас эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээлийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.2.1-13.2.2-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно.

7.2.Хууль тогтоомж болон Засгийн газрын бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан төсөл, арга хэмжээнд олгох зээлийн хүү, хугацаа, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа, зээл олгоход шаардлагатай бусад нөхцөл, шаардлага (цаашид “Ерөнхий нөхцөл” гэх)-ыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.3.Сангаас олгох зээлийн дээд хэмжээ 1,000,000,000.0 (нэг тэрбум) төгрөг байна.

7.4.Сангаас олгох зээлийн хугацаа 3 жил хүртэл, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 1 жил хүртэл байна.

7.5.Энэ журмын дагуу олгох зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна.

7.6.Хамтарсан кино бүтээх төсөл, арга хэмжээнд олгох зээлийн хэмжээ нь Монгол Улсын кино продюсерын санхүүжүүлэх зардлаас хэтрэхгүй байна.

Найм.Хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага

8.1.Сангаас зээл авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд дор дурдсанаас гадна хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээсээ хамаарч мөн журмын 8.2-8.3-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлэн журмын 3.4-т заасан хугацаанд Зөвлөлд хүсэлтээ гаргана:

8.1.1.төсөл, арга хэмжээний танилцуулга;

8.1.2.зээл хүссэн этгээдийн нэр, албан ёсны хаяг, үйл ажиллагаа явуулж буй хаяг, байршил;

8.1.3.зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо:

8.1.3.1.гадаад, дотоод орчны шинжилгээ (SWOT);

8.1.3.2.кино түгээлт, борлуулалтын орлогын тооцоо;

8.1.3.3.үйлдвэрлэлийн зардлын тооцоо;

8.1.3.4.төслийн үр ашгийн тооцоо;

8.1.3.5.төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх судалгаа, эсхүл даатгалд хамрагдах тооцоо;

8.1.3.6.хөрөнгө оруулалт, зээлийн зарцуулалтын тооцоо;

8.1.3.7.төслийн өгөөж, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа.

8.1.4.өмнө нь хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, уран бүтээлийн танилцуулга;

8.1.5.одоо эрхэлж байгаа үйл ажиллагаа, бизнесийн талаарх мэдээлэл;

8.1.6.зээлийн хүсэлт, зарцуулалт, эргэн төлөлтийн хуваарь;

8.1.7.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, үүсгэн байгуулагчийн лавлагаа, захирал, кино продюсерын иргэний үнэмлэхийн хуулбар;

8.1.8.барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тухайн үл хөдлөх эд хөрөнгө барьцаанд байгаа эсэх тухай лавлагаа;

8.1.9.зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны баталгаажсан хуулга;

8.1.10.сүүлийн 2 жилээр гаргасан санхүүгийн баталгаажсан тайлан, хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс;

8.1.11.сүүлийн 2 жилийн татварын тодорхойлолт, хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших татварын тодорхойлолт;

8.1.12.төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрснийг илэрхийлсэн мэдэгдэл.

8.2.Кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэхэд зээл авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд энэ журмын 8.1-д зааснаас гадна дараах баримт бичиг, материалыг бүрдүүлнэ:

8.2.1.төсөл хэрэгжих боломжтой үр дүнгийн урьдчилсан төсөөлөл, санхүүгийн тооцоо, төслийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн;

8.2.2.төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө;

8.2.3.төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбай, үл хөдлөх эд хөрөнгийн талаарх мэдээлэл;

8.2.4.шаардлагатай бусад баримт бичиг, материал.

8.3.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.2.1-д заасан кино бүтээхэд зээл авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд энэ журмын 8.1-д зааснаас гадна дараах баримт бичиг, материалыг бүрдүүлнэ:

8.3.1.кино зохиолын танилцуулга;



8.3.2. кино продюсер, найруулагчийн ур чадвар, туршлага, уран бүтээлийн амжилтын мэдээлэл;

8.3.3. кино бүтээл үйлдвэрлэх техникийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн мэдээлэл, жагсаалт;

8.3.4. төсөл хэрэгжих боломжтой үр дүнгийн урьдчилсан төсөөлөл, санхүүгийн тооцоо, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн;

8.3.5. оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбогдох баримт бичиг, гэрээ.

8.4. Энэ журмын 8.1-д заасан иргэн, хуулийн этгээд хүсэлтдээ хавсаргах гадаад хэл дээрх эх баримт бичгийг орчуулгын хамт ирүүлнэ. Баримт бичиг, материалын үнэн зөв байдлыг хүсэлт гаргагч бүрэн хариуцах ба шалгаруулалтын явцад шаардлагатай бусад баримт бичгийг нэмэлтээр бүрдүүлэх боломжтой байна.

Ес. Дамжуулан зээл олгох арилжааны банкийг сонгох

9.1. Дамжуулан зээл олгох арилжааны банкийг сонгон шалгаруулах, хяналт тавих ажлын удирдамж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.2. Дамжуулан зээл олгох арилжааны банк дараах шаардлагыг хангасан байна.

9.2.1. Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн нэг жилийн хугацаанд ханган ажиллаж байгаа нь Монголбанкны дүгнэлтээр нотлогдсон байх;

9.2.2. олгосон зээлийн эрсдэлийг бүрэн хариуцаж, дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгааг тухайн арилжааны банкны Монголбанкна дахь харилцах данснаас гаргасан байх;

9.2.3. сантай байгуулсан ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гэрээний үүргийг зөрчөөгүй байх;

9.2.4. гадаадын зээл, тусламжийн болон төсвийн хөрөнгөөр дамжуулан олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зөрчилгүй байх;

9.2.5. сонгон шалгаруулалтын баримт бичигт шаардсан бусад шаардлагыг хангасан байх.

9.3.Энэ журмын 9.1-д заасны дагуу сонгон шалгаруулсан арилжааны банктai Зөвлөл гэрээ байгуулан ажиллана.

Арав.Хөнгөлөлттэй зээл олгох төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, санхүүжилт олгох

10.1.Зөвлөл зээл хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 45 хоногт багтаан хуралдаж, энэ журамд заасан шаардлага, бүрдүүлбэр хангасан хүсэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

10.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ журмын 10.1-д заасан санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэр гарган зээл олгох төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, хүсэлт гаргагчийн сонгосон энэ журмын 9.3-т заасан банканд битүүмжлэн хүргүүлнэ.

10.3.Банк соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан шийдвэрийг үндэслэн жагсаалтаар хүргүүлсэн төсөл, арга хэмжээний зээлийн судалгааны материалыг 14 хоногийн дотор бүрэн хүлээн авах арга хэмжээ авч, түүнээс хойш хуанлийн 30 хоногт багтаан банкны шаардлага хангасан төсөл, арга хэмжээний жагсаалт, банкны зээлийн хорооны шийдвэр, зээлийн гэрээ, барьцааны гэрээ болон нэхэмжлэлийн хамт соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Энэ хугацаанд холбогдох шийдвэрийг ирүүлээгүй тохиолдолд шийдвэрийг хүчингүй болсонд тооцно. Үүнээс үүдэн гарах хохирлыг холбогдох этгээд хариуцна.

10.4.Зөвлөл соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлийг үндэслэн энэ журмын 10.3-т заасан банкнаас ирүүлсэн нэхэмжлэл, холбогдох материалын дагуу банканд зээлийн санхүүжилтийг олгоно.

10.5.Банк зээлийн санхүүжилтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдэд зээлийг олгоно.

Арван нэг.Зээлдэгчийн мэдээллийн сан

11.1.Зөвлөл зээл авсан иргэн, хуулийн этгээдийн холбогдох мэдээллийг агуулсан Зээлийн мэдээллийн санг бүрдүүлэн хөтөлнө.

11.2.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд тогтмол хүргүүлнэ.

Арван хоёр.Зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих

12.1.Зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.зээл авсан иргэн, хуулийн этгээдийн төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн талаарх тайлан, мэдээг арилжааны банк болон зээлдэгчээс улирал бүр гаргуулан авах;

12.1.2.сангийн зээлийн эх үүсвэрийг зүй зохистой ашиглах, нэмэгдүүлэх талаар санал, дүгнэлт гаргах, дэмжих;

12.1.3.хууль тогтоомжийн биелэлт, үйл ажиллагааны хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, шаардлагатай асуудлаар санал хүргүүлэх.

12.2.Зээл дамжуулан олгосон арилжааны банк гэрээний үүргээ биелүүлээгүй болон эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах, олгосон зээлд хяналт тавих, хяналтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдсон харилцааг энэ журмын 9.3-т заасан гэрээний дагуу зохицуулна.

Арван гурав.Сангийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалтад хяналт тавих, тайлагнах

13.1.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.5-д заасны дагуу соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хянаж, тайлагнан мөн хуулийн 25.1-д заасан журмын дагуу хяналт шалгалт хийнэ.

13.2.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9.16.6-д зааснаар Зөвлөл төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагаас гаргуулан авч, дүгнэлт хийнэ.

13.3.Сангийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудитын дүгнэлт гаргуулан тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулна.

13.4.Зөвлөл сангаас санхүүжилт, зээл авсан хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, шалгарсан төсөл, арга хэмжээний нэр, үйл ажиллагааны чиглэл, сонгон шалгаруулсан шийдвэр, эргэн төлөлтийн мэдээллийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай

хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.

13.5.Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд гүйцэтгэсэн ажлын төсвийн зарцуулалт, хүрсэн үр дүн, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, гүйцэтгэлийн тайланг гэрээнд заасан хугацаанд Зөвлөлд танилцуулах үүрэгтэй.

13.6.Сангийн хөрөнгийг хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт зааснаас бусад зориулалтаар болон хэтрүүлэн зарцуулахгүй.

13.7.Сангаас үзүүлэх дэмжлэгийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, энэ журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон иргэн, хуулийн этгээдэд олгосон санхүүжилтийг буцаан татаж, холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээг Зөвлөлийн ажлын алба зохион байгуулна.

Арван дөрөв.Бусад

14.1.Сангийн эх үүсвэрээр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

14.2.Энэ журамд заасныг зөрчиж төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3

Индекс: 200003